



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 5/36

Чингис хот

Ж.Ганбатыг ажилд томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.2, "Хэнтий-Ус" ХХК-ий Удирдах зөвлөлийн 2013 оны 06 дугаар тогтоолоор баталсан "Хэнтий-Ус" ХХК-ий дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалт, 2019 оны 01 дүгээр тогтоолын хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалын Ганбат нь хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, тус газрын 2020 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 05/8834 тоот албан бичгээр ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул 2020 оны 8 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн "Хэнтий-Ус" ХХК-ий захирлаар томилсугай.

2. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч:

Э.Мөнх-Эрдэнэ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Ц.Бат-Эрдэнэ

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө оруулалт, өмчийн бодлого хариуцсан мэргэжилтэн

Д.Ганзориг

"Хэнтий-Ус" ХХК-ий мэдээлэл технологийн Инженер

Т.Алтансүвд

"Хэнтий-Ус" ХХК-ий нярав

3. Ж.Ганбатын үндсэн цалинг 1400000 төгрөгөөр тооцон холбогдох бусад нэмэгдлийг бодож олгохыг "Хэнтий-Ус" ХХК-ий ерөнхий нягтлан бодогч /О.Ундрахбаяр/-д үүрэг болгосугай.

4. Ж.Ганбатад томилогдсоноос хойш 30 хоногийн дотор хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлгээ Төрийн захиргааны удирдлагын хэлтэс /Ж.Гантулга/-т гаргаж өгөх үүрэгтэйг сануулсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ